



"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар: 21/02

Улаанбаатар
хот

Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь хэсэг, Хөдөлмөрийн контрактын 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Улсын их дэлгүүр" ХК-ийн Гүйцэтгэх захирал Санжаагийн Сайнбаттай байгуулсан Хөдөлмөрийн контрактыг өөрийнх нь хүсэлтээр цуцалж, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Гүйцэтгэх захирлын ажлыг хүлээлцүүлж, холбогдох тооцоог хийж дуусгахыг ТУЗ-ийн хараат бус гишүүн Ө.Үнэнбүрэн, ТУЗ-ийн гишүүн А.Норсмаа, Ахлах нягтлан бодогч /Д.Чимгээ/ нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ө.ҮНЭНБҮРЭН



"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар: 21/03

Улаанбаатар
хот

Гүйцэтгэх захирал томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.4 хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс саналын хуудсаар авсан санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Улсын их дэлгүүр" ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Идэштөгтохын Галбуян /РД: ПИ89020119/-г 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.
2. Монгол Улсын хууль тогтоомж, компанийн дүрэм, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Гүйцэтгэх захирал И.Галбуянд үүрэг болгосугай.
3. Гүйцэтгэх захирлын үндсэн цалинг түүнтэй байгуулах Хөдөлмөрийн контракт дахь заасны дагуу тогтоож, бусад нэмэгдэл, хангамж, урамшууллыг холбогдох журмын дагуу тооцон олгохыг Ахлах нягтлан бодогч /Д.Чимгээ/-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэх, холбогдох өргөдлийн маягтад гарын үсэг зурах, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг гардан авах эрхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Мөнхбаярын Өлзийбат /РД: АИ84122114/-д итгэмжлэн олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ө.ҮНЭНБҮРЭН

**“Улсын их дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
санал хураалтын дүнг нэгтгэсэн тэмдэглэл**


Огноо: 2021-03-01

Д/д	Санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал	Санал хураалтын ирц	Санал өгсөн ТУЗ-ийн гишүүн	ТУЗ-ийн гишүүний санал
1	Санжаагийн Сайнбатыг Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлж, компанийн Гүйцэтгэх захирлаар Идэштөгтохын Галбуянг томилох тухай.	89%	Ш.Баярсайхан	Зөвшөөрсөн
			Ө.Үнэнбүрэн	Зөвшөөрсөн
			Я.Наваан	Зөвшөөрсөн
			Б.Бямбаноров	Зөвшөөрсөн
			А.Норсмаа	Зөвшөөрсөн
			С.Хосбаяр	Зөвшөөрсөн
			Д.Дашцэдэн	Зөвшөөрсөн
			Н.Батцацрал	Зөвшөөрсөн

Санал хураалтын дүнг: ТУЗ-ийн нийт 9 гишүүнээс 8 гишүүн санал өгсөн ба санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг санал өгсөн гишүүдийн 100%-ийн саналаар зөвшөөрсөн.

Санал хураалтын дүнг нэгтгэсэн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:



М.Өлзийбат